

“БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

## БАРАА ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер  
шалгаруулалтын  
нэр:

*Автомашины сэлбэгийн 5 багц*

Тендер  
шалгаруулалтын  
дугаар:

*НТШ№24/22*

***БЗӨБЦТСТӨХК/20240102029***

## I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ).....	1
1. Тендерийн цар хүрээ.....	1
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг.....	1
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж.....	1
4. Сонирхогч этгээд, оролцогч.....	2
5. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ.....	2
6. Нийлүүлэх барааны гарал үүсэл.....	2
7. Тендер шалгаруулалтын баримт бичиг.....	3
8. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах.....	3
9. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт.....	3
10. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл.....	3
11. Тендерийн иж бүрдэл.....	4
12. Тендерийн жишиг маягтууд.....	5
13. Хувилбарт санал.....	5
14. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг.....	5
15. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг.....	5
16. Чадавхын болон туршлагын шаардлага.....	7
17. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт.....	7
18. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт....	8
19. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт.....	8
20. Тендерийн валют.....	9
21. Тендер хүчинтэй байх хугацаа.....	9
22. Тендерийн баталгаа.....	9
23. Тендер баталгаажуулах, илгээх.....	9
24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа.....	10
25. Тендерийн талаар тодруулга авах.....	10
26. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх.....	10
27. Тендерийг үнэлэх.....	10
28. Арифметик алдааг залруулах.....	10
29. Оролцогчид давуу эрх олгох.....	11
30. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт.....	11
31. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох.....	11
32. Тендерийг эрэмбэлэх.....	11

33.	Оролцогчийн чадавхыг дахин магадлах .....	11
34.	Мэдэгдэл хүргүүлэх .....	11
35.	Гүйцэтгэлийн баталгаа.....	12
36.	Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах.....	12

## I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

### А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- |  |   |
|--|---|
| <b>1. Тендерийн цар хүрээ</b>                        | <b>1.1.</b> Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид <b>“Хууль”</b> гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон бараа, түүний дагалдах үйлчилгээ (цаашид <b>“бараа”</b> гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.  |
|  | 1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.  |
|  | 1.3. Барааг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой багцын барааг хуулийн 8.1-д зааснаар дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой бол энэ тухай захиалагч өгөгдлийн хүснэгтэд заана. Ийнхүү заасан бол тендер шалгаруулалт, эсхүл түүний багцад зөвхөн Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлнэ.   |
|  | 1.4. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгт болон зарлалд заана.  |
| <b>2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг</b> | 2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.   |
| <b>3. Худалдан аваж ажиллагааны хууль тогтоомж</b>   | 3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.  |
| <b>4. Худалдан аваж ажиллагааны цахим систем</b>     | 4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем ( <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> ) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.  |
| <b>5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх</b> | 5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ. |

- 5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20<sup>1</sup>, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.
- 6. Сонирхогч оролцогч этгээд,**
- 6.1. Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.
- 6.2. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.
- 6.3. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.
- 6.4. Тендер шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т заасан үйлчилгээний хураамж төлсөн байна.
- 6.5. ТШЗ-ны 6.4-т заасан үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.
- 7. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ**
- 7.1. Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.
- 7.2. Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.
- 7.3. Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.
- 7.4. ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.
- 7.5. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 8. Нийлүүлэх барааны гарал үүсэл**
- 8.1. ТШЗ-ны 1.3-т өөрөөр заагаагүй бол гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно.

## **Б.АГУУЛГА**

**9. Тендер шалгаруулалтын баримт бичиг**

9.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:  
I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;  
II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;  
III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;  
IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;  
V Бүлэг. Тендерийн жишиг маягт;  
VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

9.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

9.3. Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтөд нийцүүлэн тендер бэлтгэнэ.

**10. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах**

10.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтийг хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар захиалагчид гаргах бол Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүргүүлнэ.

10.2. ТШЗ 10.1-д заасан хүсэлтэд ТШЗ-ны 6.4-т заасан сонирхогч этгээд болохыг нотлох баримтыг хавсаргана.

10.3. Тодруулгын дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл захиалагч хуулийн 20.6-д заасны дагуу шийдвэрлэнэ.

**11. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**

11.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана. Захиалагч уулзалтад ТШЗ-ны 6.6-д заасан сонирхогч этгээд, түүний төлөөллийг оролцуулна.

11.2. ТШЗ-ны 11.1-д заасан уулзалтад оролцоогүй нь аж ахуй эрхлэгчийн тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

**В. ТЕНДЕР БЭЛТГЭХ**

**12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл**

12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

- 12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн ТШЗ-ны 12.1-д заасан хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.
- 12.3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн хэл болон гадаад хэлээрх хувилбар хоорондоо зөрвөл ТШЗ-ны 12.1-д заасан хэлээр бэлтгэсэн тендер шалгаруулалтын баримт бичгийг баримтална.
- 12.4. Захиалагч ТШЗ-ны 12.1-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг тендер хянан үзэх, үнэлэхэд ашиглах ба оролцогч өөрөө орчуулсан, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

### **13. Тендерийн иж бүрдэл**

- 13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн бараа нийлүүлэх техникийн болон үнийн санал байна.
- 13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:
  - 13.2.1. ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасны дагуу бэлтгэсэн маягтууд;
  - 13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;
  - 13.2.3. захиалагч зөвшөөрсөн бол ТШЗ-ны 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;
  - 13.2.4. оролцогч ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;
  - 13.2.5. санал болгож буй бараа ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;
  - 13.2.6. бараа нийлүүлэлтийн хуваарь;
  - 13.2.7. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 18, ТШЗ 19, ТШЗ 20 дугаар зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;
  - 13.2.8. ТШЗ-ны 21 дүгээр зүйлд заасан барааны үнийн задаргаа;
  - 13.2.9. ТШЗ-ны 21.9-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;
  - 13.2.10. түншлэл бол хуулийн 6.3-т заасан түншлэлийн гэрээ.

- 13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.
- 13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.
- 14. Тендерийн маягтууд жишиг** 14.1. Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтын дагуу илгээнэ.
- 15. Хувилбарт санал** 15.1. Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан заасан тохиолдолд оролцогч хуулийн 11.10-т заасанд нийцэх хувилбарт саналыг тендерт ирүүлж болно.
- 16. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг** 16.1. Оролцогч хуулийн 7.2-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ.
- 16.2. Монгол Улсын хуулийн этгээд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ.
- 16.3. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:
- 16.3.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;
- 16.3.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;
- 16.3.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.
- 16.4. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 14.2, 14.3-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.
- 17. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг** 17.1. Нийлүүлэхээр санал болгох барааны гарал үүслийн мэдээллийг V бүлгийн Маягт 2-ын холбогдох хэсэгт бөглөж ирүүлнэ.
- 17.2. Хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендерт ирүүлэхийг шаардахгүй.



- 17.3. Оролцогчийн санал болгож буй бараа нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлох баримтыг өгөгдлийн хүснэгтэд зааснаар тендерт ирүүлнэ.
- 17.4. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол оролцогч өөрийн санал болгож байгаа бараанд холбогдох загвар, дээжийг тендер нээх эцсийн хугацаанаас өмнө захиалагчид хүргүүлэх ба шалгалт, туршилтыг хийх ажиллагаанд оролцогчийг өгөгдлийн хүснэгтэд зааснаар оролцуулна.
- 17.5. Нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас хэлбэрээр байж болно. Санал болгох бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэнийг харуулах зорилгоор тэдгээрийн техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг техникийн тодорхойлолттой нийцсэн болохыг хянан үзэх боломжтой баримт, хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарласан тайлбар ирүүлсэн байна.
- 17.6. Барааг нийлүүлснээс хойш өгөгдлийн хүснэгтэд заасан хугацааны туршид тасралтгүй, горимын дагуу ашиглахад шаардагдах өгөгдлийн хүснэгтэд заасан сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалтыг тэдгээрийг авах боломжтой хаяг, үнийн мэдээллийн хамт ирүүлнэ.
- 17.7. Техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал, тоног төхөөрөмжийн загвар, хэмжих нэгж, стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар зэрэг нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.
- 17.8. Гадаадын этгээдийн хувьд гэрээний дагуу хийгдэх техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг үзүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрөө, эсхүл өөрийн Монгол Улсад байгуулсан буюу байгуулах салбар, төлөөний газар, эсхүл бусад төлөөлөгч гүйцэтгэх тухай баримт;
- 17.9. Монгол Улсын гарал үүсэлтэй бус бараа нийлүүлэхээр санал болгосон оролцогч нь техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай баримт болон мэдээлэл;
- 17.10. Хуулийн 8.4-т зааснаар давуу эрх тооцуулах барааны Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлснээр Сангийн сайдын баталсан Давуу эрх олгох аргачлал, зааврын дагуу тооцно. Барааны үнийн задаргаанд Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг заагаагүй, эсхүл гарал үүслийг нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх тооцохгүй.

- 17.11. ТШЗ-ны 1.3-т зааснаар нийлүүлэхээр санал болгох бараа Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ. Нотлох баримт бичиг ирүүлээгүй тохиолдолд тухайн барааг шаардлага хангаагүй гэж үзнэ.
- 17.12. Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс нийлүүлэхээр санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 18. Чадавхын болон туршлагын шаардлага**
- 18.1. Захиалагч санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг өгөгдлийн хүснэгтэд заах ба хуулийн 15 дугаар зүйлд заасныг баримтална.
- 18.2. Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана. Тухайн бараа, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нэг зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг захиалагч шаардсан бол түншлэлийн гишүүн тус бүр уг шаардлагыг хангасан байх шаардлагатай. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.
- 18.3. Түншлэл нь ТШЗ-ны 18.1-д заасан доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна. Борлуулалтын орлогын хэмжээ, ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтийг ТШЗ-ны 18.1-д заасан бол төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
- 18.4. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.
- 19. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт**
- 19.1. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 19.2. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

- 19.3. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.
- 20. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт**
- 20.1. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5-д заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.
- 21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт**
- 21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.
- 21.2. Барааны үнийн задаргаанд багц тус бүрийн барааны нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг тусгаж ирүүлнэ.
- 21.3. Оролцогч үнийн хөнгөлөлт санал болгох бол ТШЗ-ны 14-т заасан тендер илгээх маягтад заана.
- 21.4. ТШЗ 21.3-т зааснаар үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг тендерийн үнэ гэж үзнэ.
- 21.5. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.
- 21.6. Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг Олон улсын худалдааны нөхцөл /Incoterms/-ийг хэрэглэхдээ өгөгдлийн хүснэгтэд заагаагүй бол хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ нөхцөлийг бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.
- 21.7. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.
- 21.8. ТШЗ-ны 21.2-т заасан барааны үнийн задаргааны нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч тендер илгээх маягтад үнээс зөрүүтэй бол барааны үнийн задаргааны нийт нийлбэрийг тендер илгээх маягтын үнэ гэж үзнэ.

- 21.9. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.
- 22. Тендерийн валют**
- 22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.
- 23. Тендер хүчинтэй байх хугацаа**
- 23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.
- 23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.
- 23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь худалдан авах барааны санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.
- 24. Тендерийн баталгаа**
- 24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 24.2. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрээр ТШЗ-ны 24.1-д зааснаар ирүүлнэ.
- 24.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.
- Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ**
- 25. Тендер баталгаажуулах, илгээх**
- 25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.
- 25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

- 25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.
- 25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 6-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.
- 25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.
- 26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**
- 26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.
- 26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

#### **Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ**

- 27. Тендерийн талаар тодруулга авах**
- 27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.
- 28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх**
- 28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасан иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн хянан үзнэ.
- 29. Тендерийг үнэлэх**
- 29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.
- 29.2. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.
- 30. Арифметик алдааг залруулах**
- 30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.
- 30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.

- 31. Давуу эрх олгох**
- 31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн дотоодын бараанд хуулийн 8.4-т зааснаар давуу эрх олгож, дотоодын барааны хэсгийн үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.
- 31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.
- 31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.
- 32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт**
- 32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
- 33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох**
- 33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална.
- 33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ.
- 33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
- 34. Тендерийг эрэмбэлэх**
- 34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална.
- 35. Оролцогчийн чадавхыг магадлах дахин**
- 35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг дахин магадална.
- 35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 19 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 20 дугаар зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.
- 35.3. ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

## **Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ**

- 36. Шийдвэр хүргүүлэх**
- 36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.

**37. Гүйцэтгэлийн  
баталгаа**

37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.

37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.

**38. Гэрээнд гарын үсэг  
зурж баталгаажуулах**

38.1. Захиалагч ТШЗ-ны 9.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.

38.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

## II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ӨХ)

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: <b>БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ</b>
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: <b>НТШ№24/22 дугаартай Автомашины сэлбэгийн 5 багц</b>
ТШЗ 1.1	Тендерийн урилгын дугаар: <b>БЗӨБЦТСТӨХК/20240102029</b>
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Багц №1</b> Авто машины сэлбэг /Компани, Багануур салбар/ <b>Багц №2</b> Авто машины сэлбэг /Дорноговь салбар/ <b>Багц №3</b> Авто машины сэлбэг /Дундговь салбар/ <b>Багц №4</b> Авто машины сэлбэг Хэнтий салбар <b>Багц № 5</b> Авто машины сэлбэг /Говьсүмбэр салбар/
ТШЗ 1.3	Дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа байгаа бол тодорхой бич: <b>Үгүй.</b>
ТШЗ 1.4	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: <b>Үгүй.</b>
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <b>Өөрийн хөрөнгө</b>



ТШЗ 2.1	<p>Нийт төсөвт өртөг: <b>133,365,100 (Нэг зуун гучин гурван сая гурван зуун жаран таван мянга нэг зуун) төгрөг.</b></p> <p><b>Багц№ 1 Автомашины сэлбэг /Компани, Багануур салбар/</b></p> <p>Төсөвт өртөг: 46,590,500 (Дөчин зургаан сая таван зуун ерэн мянга таван зуун) төгрөг</p> <p><b>Багц№ 2 Автомашины сэлбэг /Дорноговь салбар/</b></p> <p>Төсөвт өртөг: 30,118,000 (Гучин сая нэг зуун арван мянган) төгрөг</p> <p><b>Багц№ 3 Автомашины сэлбэг /Дундговь салбар/</b></p> <p>Төсөвт өртөг:21,715,100 (Хорин нэгэн сая долоон зуун арван таван мянга нэг зуун ) төгрөг</p> <p><b>Багц№ 4 Автомашины сэлбэг /Хэнтий салбар/</b></p> <p>Төсөвт өртөг: 28,854,100 (Хорин найман сая найман зуун тавин дөрвөн мянга нэг зуун ) төгрөг</p> <p><b>Багц№ 5 Автомашины сэлбэг /Говьсүмбэр салбар/</b></p> <p>Төсөвт өртөг: 6,087,400 (Зургаан сая наян долоон мянга дөрвөн зуун) төгрөг</p>
<b>Б. АГУУЛГА</b>	
ТШЗ 8.1	<p>Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг:</p> <p>Хүлээн авагчийн нэр: <b>Худалдан авах ажиллагаа хангамжийн хэлтэс</b></p> <p>Хаяг: <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> төрийн худалдан авах ажиллагааны цахим систем</p> <p>Утасны дугаар: <b>99105839</b></p> <p>Цахим шуудангийн хаяг: <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> төрийн худалдан авах ажиллагааны цахим систем</p>
ТШЗ 11.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: <b>Үгүй</b>
<b>В. ТЕНДЕР БЭЛТГЭХ</b>	
ТШЗ 12.2	Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэл: <b>Монгол хэл</b> Тендерийн баримт бичиг тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, тендер оролцогчдын ирүүлэх тендер <b>Монгол</b> хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг заавал баталгаат орчуулгын хамт <b>Монгол</b> хэл дээр ирүүлнэ.
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: <b>Зөвшөөрөхгүй.</b>
ТШЗ 16.1	Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: <b>“Шаардана”</b>

	<p>1. Улсын бүртгэлийн гэрчилгээ</p> <p>2. Тендер нээсэн өдрийн байдлаар Монгол Улсын хуулийн дагуу хугацаа хэтэрсэн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөргүй байх шаардлагатай.</p> <p>Жич: Улсын бүртгэлийн гэрчилгээ, татвар болон нийгмийн даатгалын тодорхойлолтыг тендерийн баримт бичигт хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” (www.tender.gov.mn)-ээр дамжуулан шалгана.</p>
<b>ТШЗ 16.2</b>	<p>Шүүхийн тусгай архивын лавлагаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг цахим хэлбэрээр авна.</p> <p>Тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлт хийхээс 3-аас доошгүй хоногийн өмнө нэвтрэн орж шүүхийн тусгай архивын лавлагаа авах хүсэлтийг илгээх бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөл хянан үзэж лавлагаа цахимаар илгээдэг болохыг анхааруулна уу.</p> <p>Жич: Дээрх лавлагаа авах зааварчилгаатай www.tender.gov.mn цахим системийн хэрэглэгчийн хөтөч цэснээс танилцана уу. Хэрэв дээрх тодорхойлолтуудыг цахимаар ирүүлэхгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p><i>Харьяа Шүүхийн тамгын газрын тодорхойлолт ирүүлнэ.</i></p>
<b>ТШЗ 16.3.1</b>	Хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг ирүүлнэ.
<b>ТШЗ 17.4</b>	Тендер нээх эцсийн хугацаанаас өмнө загвар, дээж ирүүлэх эсэх: <b>Үгүй</b>
<b>ТШЗ 17.6</b>	Барааны хувьд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад эд зүйлсийн жагсаалт ирүүлэх эсэх, ирүүлэх бол хугацаа: <b>Үгүй</b>
<b>ТШЗ 18.1</b>	<p>Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн шаардлага, шалгуур үзүүлэлт: <b>“Шаардахгүй”</b></p> <p>Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага: <b>Шаардлагатай</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Сүүлийн 2 жилийн аль нэг жилд дор хаяж 1-с доошгүй удаа (2022, 2023 он) хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй бараа нийлүүлсэн мэдээллийг Ү бүлгийн Маягт 3, Маягт 5-ын дагуу бэлтгэн ирүүлэх ба гэрээ, гэрээ дүгнэсэн акт, захиалагчийн тодорхойлолт ирүүлнэ.</li> <li>- Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээ (2022, 2023 он) хугацааны аль нэг жилд гэрээний дүнгээр батлагдсан төсөвт өртгийн 100 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байх.</li> <li>- Ижил төстэй бараа гэдэгт санал болгосон бараа болон түүнтэй дүйцэхүйц Автомашины сэлбэг бараа нийлүүлсэн туршлагыг хамааруулан үзнэ.</li> </ul>

	<p>( Өмнөх онуудад Захиалагч байгууллагатай хамтран ажиллаж байсан бол гэрээний үүргээ биелүүлсэн тухай захиалагчийн тодорхойлолт ирүүлнэ. Хамтран ажиллаж байгаагүй бол энэ тухай албан бичиг ирүүлнэ.)</p> <p>Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн шаардлага: <b>“Шаардахгүй”</b></p> <p>Оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага:</p> <p><b>Сүүлийн хоёр жилийн (2022, 2023) борлуулалтын орлого жил тус бүр төсөвт өртгийн 100%-аас багагүй байна.</b></p>
<p><b>ТШЗ 18.2</b></p>	<p>Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: <b>Шаардахгүй.</b></p>
<p><b>ТШЗ 19.1</b></p>	<p>Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх: <b>“Тийм”</b></p> <p><b>-2022, 2023 онуудын санхүүгийн хураангуй тайлан, аудитын дүгнэлтийн хамт ирүүлэх.</b></p> <p>2022, 2023 оны санхүүгийн тайлан e-balance цахим бүртгэлд шивэгдэж баталгаажсан байх шаардлагатай, санхүүгийн тайлан цахим бүртгэлд шивэгдээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: <b>2022, 2023 он</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 100 хувиас багагүй байна. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр тодорхойлно. Үүнд: <ol style="list-style-type: none"> <li>a. Цахим системээс татагдсан түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ. (Цахим системээс шалгах тул ирүүлэх шаардлагагүй)</li> <li>b. Арилжааны банкнаас олгох зээлийн мөнгөн дүн бүхий тодорхойлолт ирүүлнэ. (Судалж, зохих журмын дагуу зээл олгох боломжтой гэсэн тодорхойлолт шаардлага хангахгүй).</li> </ol> </li> <li>2. Харилцагч банкнаас хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн өр төлбөргүй талаарх тодорхойлолт ирүүлнэ.</li> <li>3. Харилцагч банкнаас лавлагаа авахад татгалзах зүйлгүй тухай тодорхойлолт ирүүлнэ.</li> <li>4. Харьяа нийгмийн даатгалын хэлтэс, татварын хэлтсээс тендертэй холбоотой асуудлаар лавлагаа авахад татгалзах зүйлгүй тухай албан бичиг ирүүлнэ.</li> </ol> <p>Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдийн лавлагаа</p>
<p><b>ТШЗ 20.1</b></p>	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэх эсэх: <b>“Тийм”</b></p>

	<ul style="list-style-type: none"> <li>- Барааны үнийн задаргаа, бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу ирүүлнэ. (Багц тус бүр дээр бараануудыг жагсааж бичиж ирүүлнэ.) <b>Багц№ 1 Автомашины сэлбэг / Компани, Багануур салбар/ материалаас урьдчилан худалдан авалт хийсэн тул үнийн саналаас 18,700,000 төгрөг хасч тооцон үнийн санал ирүүлнэ үү.</b></li> <li>- Тендерийн материалыг PDF форматаар цахим хэлбэрээр тод гаргацтай байдлаар цахим системээр ирүүлэх ба гаргацгүй тохиолдолд уг материалыг ирүүлээгүйд тооцно.</li> <li>- Тендерийн баримт бичиг, гэрээний ерөнхий болон гэрээний тусгай нөхцөлийн 2.10, 3.9, 4.10 дугаар заалтыг хүлээн зөвшөөрсөн албан мэдэгдэл ирүүлнэ.</li> <li>- Тендерт оролцогчийн ирүүлсэн тендерийн баримт бичиг, саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлэг ирүүлнэ.</li> <li>- НӨАТ төлөгчийн гэрчилгээний хуулбар эсвэл цахим лавлагаа ирүүлнэ. НӨАТ төлөгч биш бол энэ тухай албан бичиг ирүүлнэ.</li> <li>- Захиалагч байгууллагатай сүүлийн 2 жилийн хугацаанд гэрээ байгуулж ажиллаж байсан бол гэрээний үүргээ биелүүлсэн тухай захиалагчийн тодорхойлолт ирүүлнэ. Гэрээ байгуулж байгаагүй бол энэ тухай албан тоот ирүүлнэ.</li> <li>- Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан, техникийн тодорхойлолтын дагуу барааг захиалагчид нийлүүлэх, гологдол гарсан тухай бүрт яаралтай арилгах баталгааг албан бичгээр гаргаж ирүүлнэ.</li> </ul> <p>Оролцогч нь өөрийн болон түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээллийг V бүлгийн Маягт 4-ын дагуу ирүүлнэ.</p>
<b>ТШЗ 21.5.</b>	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: <b>“Тохируулахгүй тогтмол байна”</b>
<b>ТШЗ 21.6</b>	Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: <b>Incoterms 2020, DDP</b>
<b>ТШЗ 24.1</b>	Тендерийн баталгааны дүн: <b>666,825.5 төгрөг.</b>
<b>Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ</b>	
<b>ТШЗ 25.5.</b>	Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:
<b>ТШЗ 26.1.</b>	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: <b>2024 оны 06 дугаар сарын 12-ний өдөр</b> Цаг: <b>09 цаг 30 минут</b>
<b>ТШЗ 26.2.</b>	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: <b>2024 оны 06 дугаар сарын 12-ний өдөр</b>

	Цаг: <b>10 цаг 00 минут</b> Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: <b>Улаанбаатар хот, Багануур дүүрэг, БЗӨБЦТС ТӨХК Өөрийн байр</b>
<b>Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ</b>	
<b>ТШЗ 29.2.</b>	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: <b>Үгүй.</b>
<b>ТШЗ 31.1.</b>	Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг:
<b>ТШЗ 32.1</b>	Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх: <b>Ашиглахгүй.</b>
<b>ТШЗ 37.1</b>	<b>Гэрээ байгуулах эрх авсан оролцогч гэрээ батлагдахаас өмнө төсөвт өртгийн 3 хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг ирүүлнэ.</b>

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

**БАГЦ №1 БАРАА МАТЕРИАЛЫН ТОО ХЭМЖЭЭ**

ТӨВ КОМПАНИ ХЭСГИЙН АВТОМАШИНУУДЫН  
СЭЛБЭГИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Д/д	АВТОМАШИНЫ МАРК	СЭЛБЭГ ХЭРЭГСЛИЙН НЭР	ХЭМЖИХ НЭГЖ	ТОО	ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АРЛЫН ДУГААР, СЭЛБЭГИЙН ТИП
1	2	3	4	5	6
1	ГАЗЕЛЬ 61-06 УБД	Тосны шүүр	ш	1	LZZ5CLSB4KD576540
		Суудлын бүрээс	ком	1	
		Шал резин	ком	1	
		Агаар шүүгч	ш	1	
2	DONGPENG БРА 44-54	Нумны хорио	ш	4	LGAX4B449CL001983
		Тосны шүүр	ш	2	
		Агаар шүүгч	ш	2	
		Түлшний шүүр том	ш	2	
		Түлшний шүүр жижиг	ш	2	
		Богино кардан гол	ком	1	
		Чагтан гол	ш	2	
		Бүхээг халаагч /24v/	ком	1	
		Тормозны хийн тэлэгч аппарат	ш	2	
3	DELICA 33-89 БРА	Агаар шүүгч	ш	1	PD6W0901896
		Тосны шүүр	ш	2	
		Өндгөн тулгуур /доод/	ш	2	
		Өндгөн тулгуур /дээд/	ш	2	
		Амортизатор	ш	4	
		Очлуур	ш	4	
4	ЗИЛ-131 00-15 БРА	Бензин насос	ш	1	854793
		Карбюратор	ш	1	
5	XCMG 25 тн АВТОКРАН 81-76 УНГ	Агаар шүүгч	ком	2	LXGCPA329PA002106
		Тосны шүүр	ш	2	
		Түлшний шүүр	ш	4	
		Амортизатор	ш	2	
		5D шалавч	ш	1	
		Бүхээг халаагч/24v/	ком	1	
		Халуун тогоо/24v/	ком	1	
		Түлшний сав /300л/	ш	1	
1	2	3	4	5	6
6	ПИКАП LAND- 79 БРА 14-50	Плунжер	ком	1	JTELB71J607007738
		Салхины шил	ш	1	
		Амортизатор	ш	4	
		Хаалганы дотор	ш	2	

		Шил өргөгч зөв тал	ш	1	
		эсгий сальник	ком	1	
		Кундактор	ш	1	
		урд хагас сальник	ш	2	
		Хойд хагас голны сальник	ш	2	
		Чагтан гол	ш	2	
		Агаар шүүгч	ш	1	
		Захын дамжуулагч	ш	2	
		Түлшний шүүр	ш	1	
		Ширмэн гарны цөн	ком	2	
		Тосны шүүр	ш	2	
7	SONATA-7 51-83БРА	Тосны шүүр	ш	2	KMHEB41BBBA179394
		Агаар шүүгч	ш	1	
		Урд Их гэрэл	ш	2	
		Урд гуфер	ш	1	
8	HOWO-4257 52-52 БРА	Чиргүүлийн тормозны тэлэгч аппарат	ш	2	LZZ5CLSB4KD576540
		Тосны шүүр	ш	2	
		Агаар шүүгч	ш	2	
		Түлшний шүүр	ш	2	
9	HIACE 38-73 УЕН	Амортизатор	ш	4	TRH2190027927
		Тосны шүүр	ш	2	
		Наклад /урд /	ш	1	
		Хойд нумны түлк	ш	12	
		Хойд нумны ээмгэн холбоос	ш	2	
		Наклад /хойд /	ш	1	
		Агаар шүүгч	ш	2	
		Шалавч /Урд/	ш	1	
		Суудлын бүрээс	ком	1	
10	CAMRY 97-50 УБМ	Тосны шүүр	ш	2	4T1BF1FKXHU291046
		Наклад (урд)	ком	1	
		Пүрш (урд)	ш	2	
		Пүрш (хойд)	ш	2	
		Босоо тэнцүүлэгч	ком	1	
		Салон шүүр	ш	1	
		Агаар шүүгч	ш	1	
11	12-86 УР CAT-426F	Агаар шүүр	ш	2	CAT0426FCEJ403565
		Тосны шүүр	ш	2	
		Гидрийн шүүр	ш	1	
		Шанаганы шүд	ком	1	
1	2	3	4	5	6
11	12-86 УР CAT-426F	Түлшний шүүр	ш	2	CAT0426FCEJ403565
		Түлшний жижиг шүүр	ш	2	
12	BONGO-III 74-52 УАВ	Түлшний шүүр	ком	1	KNCWJZ76AEK843653
		Тосны шүүр	ш	2	

		Хос тросс	КОМ	1	
		Агаар шүүгч	Ш	1	
13	SONATA-YF 31-61 БРА	Амортизатор/урд,хойд/	Ш	4	KMHEC41LBFA673280
		Тосны шүүр	Ш	2	
		Агаар шүүгч	Ш	1	
		Амортизаторын өндөрлөгөө	Ш	4	
		Урд гуфер	Ш	1	
		Кондейшн мотор	КОМ	1	
		Ремень	Ш	1	
		Катушка	Ш	4	
		Их гэрэл	Ш	2	
		Очлуур	Ш	4	

**БАГАНУУР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ САЛБАРЫН АВТОМАШИНУУДЫН  
СЭЛБЭГИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

Д/д	АВТОМАШИНЫ МАРК	СЭЛБЭГ ХЭРЭГСЛИЙН НЭР	ХЭМЖИХ НЭГЖ	ТОО	ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АРЛЫН ДУГААР,СЭЛБЭГИЙН ТИП
1	2	3	4	5	6
1	УАЗ-пургон 19-09 БРА	Хойд нум	КОМ	2	374100E0440690
		Хойд тормозны пиланз (базагчтайгаа)	КОМ	2	
		Согтуу араа	Ш	1	
		Аяга араа	Ш	2	
		Урд мостны араа	Ш	2	
		Шарик 307	Ш	2	
		Шарик 306	Ш	2	
		Ташуу туслах хурдны хайрцагны гадна их бие	Ш	1	
		Хойд стүвц	КОМ	2	
		Агаар шүүгч	Ш	2	
		Маслын шүүр	Ш	2	
		Очлуур	Ш	4	
2	Nissan gabstar 48-54 БРА	Маслын шүүр Fronter	Ш	1	LJN0KB527DX118134
		Агаар шүүгч (Nissan cabstar)	Ш	1	
		Тоормосны тэлэгч (Nissan cabstar)	Ш	4	
		Хойд гэрэл (Nissan cabstar)	Ш	2	
		Чагтан гол (Урд, хойд)	Ш	1	
		Хөөх помп	Ш	2	
		Халаагч (Fronter)	Ш	4	
Порсунк (Fronter)	Ш	4			
3	Nissan navara 97-50 УЕЕ	Маслын шүүр	Ш	1	MNTCCND23Z0011207
		Агаар шүүгч	Ш	1	
		Наклад (урд)	Ш	2	
		Наклад (Хойд)	Ш	2	



		Гар карданы наклад	КОМ	1	
		Амортизатор (урд)	Ш	2	
		Амортизатор (Хойд)	Ш	2	
		Урд босоо тэнцүүлэгч	Ш	2	
4	SONATA-6 24-32 БРА Үйлдвэрлэгдсэн он:2011	Маслын шүүр	Ш	1	KMHEU41MABA799757
		Гидрийн насос	Ш	1	
		Паарны радиатор	Ш	1	
		Таван бул, гурван бул лоомон голтойгоо	Ш	2	
		Агаар шүүгч	Ш	1	
		Ком түлк (урд)	КОМ	1	
		Ком түлк (хойд)	КОМ	1	
		Дээд өндгөн тулгуур	Ш	2	
		Доод өндгөн тулгуур	Ш	2	
		Хэвтээ тэнцүүлэгч (хойд)	Ш	1	
		Босоо тэнцүүлэгч	Ш	2	
		Амортизатор (урд)	Ш	2	
		Амортизатор (Хойд)	Ш	2	
		Пүрш (урд, хойд)	Ш	4	
		Кундактор	Ш	1	
		Урд гупер	Ш	1	
		Урд элгэвч	Ш	1	
		Суудлын бүрээс	КОМ	1	
		Под кирла (L,R)	Ш	2	
		5	Kia-bongo 18-96 БРА Үйлдвэрлэгдсэн он: 2008 Даац:1.4 тн	Агаар шүүгч	
Нум /урд/	КОМ			2	
Амортизатор	Ш			2	
Стермэн	Ш			2	
Бөөр араа	Ш			1	
Ул араа	Ш			1	
1-р гол шарик	Ш			1	
2-р гол шарик	Ш			1	
Мүфт шарик	Ш			1	
Порсунк (Fronter)	Ш			4	
Апаратур (Fronter)	КОМ			1	
Хөөх помп	КОМ			1	
Стартор (Fronter)	Ш			1	
Маслын шүүр (Fronter)	Ш			2	
Урд нүүр (Bongo III)	Ш			1	
Урд гупер (Bongo III)	Ш			1	
Урд их гэрэл (Bongo III)	Ш			2	
Хойд гэрэл (Bongo III)	Ш	1			
6	Hyundai track 25-61 БРА Үйлдвэрлэгдсэн он:2002 Өрөмтэй кран 5тн	Маслын шүүр	Ш	1	KMCLK19RP2C001054
		Түлшний шүүр	Ш	2	
		Агаар шүүгч	Ш	1	
		0 шүүр	Ш	1	
		Урд нумны (түлк, пальц)	КОМ	4	
		Домакратны төмөр трүп (шингэн)	Ш	4	

1	2	3	4	5	6
		Барбаны үзүүрийн шариг (урд, хойд)	ш	4	
6	Hyundai track 25-61 БРА Үйлдвэрлэгдсэн он:2002 Өрөмтэй кран 5тн	Барбаны угын шариг (урд, хойд)	ш	4	KMCLK19RP2C001054
		Барбаны сальник үзүүрийн	ш	4	
		Босоо пальц	ш	2	
		Спидометрын гол	ш	1	
		Маслын насос	ш	1	
		Хөөх помп	ш	1	
		Хойд нумны (втүлк, пальц)	ш	4	
		Үрүүлийн шарнер	ш	2	
		Дагуу таяг	ш	1	
7	Мотоцикл (SENKE) 87-87 УРА Үйлдвэрлэсэн он:2018	Гинж	ш	1	
		Таваг араа	ш	1	
		Толь	ш	2	
		Спидометрын гол	ш	1	
		Гар базуур	ш	2	
		Дохио (Урд, хойд)	ш	4	
		Тоормозны тросс (Урд)	ш	1	
8	Шинэ Өрмийн кран	Маслын шүүр	ш	2	
		Түлшний шүүр	ш	1	
		Агаар шүүгч	ш	2	
		0 шүүр	ш	2	
9	Toyota probox 95-72 УАО Үйлдвэрлэсэн он:2023	Маслын шүүр	ш	4	NCP550110901
		Агаар шүүгч	ш	2	
		Салоны агаар шүүгч	ш	2	
		Жанам (14V)	ш	1	
		Гидрийн насос	ш	1	
		Ферда диск	ш	1	
		Мүфт шарик	ш	1	
		Очлуур	ш	4	
		Кадушка	ш	4	
		Жанамны ремен	ш	1	
		Амортизатор	ш	4	
		Гарны түлк резин	КОМ	2	
		Таван бул	КОМ	2	
		Босоо тэнцүүлэгч	ш	2	
		Очлуур	ш	4	
		Пүрш	ш	4	

## БАГЦ №1 БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

*[Захиалагч доорх хүснэгтийн 1-6 хүртэлх баганыг, тендерт оролцогч 7 дугаар баганыг бөглөнө ]*

№	Барааны нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	Өгөгдлийн хүснэгтэд заасан барааг хүргэх эцсийн цэг	Бараа нийлүүлэх хугацаа	
					Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа)	Нийлүүлэгчийн санал болгох хугацаа (Оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7
				<i>БЗӨБЦТС ТӨХК-ны Төв компаний байр</i>	<i>30 хоног</i>	<i>[6 дугаар баганад заасан хугацаанд багтаан нийлүүлэхээр санал болгож буй хугацааг бичих]</i>

## БАГЦ №2 БАРАА МАТЕРИАЛЫН ТОО ХЭМЖЭЭ

ДОРНОГОВЬ ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ САЛБАРЫН АВТОМАШИНУУДЫН  
СЭЛБЭГИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Д/д	АВТОМАШИНЫ МАРК	СЭЛБЭГ ХЭРЭГСЛИЙН НЭР	ХЭМЖИХ НЭГЖ	ТОО	ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АРЛЫН ДУГААР, СЭЛБЭ ГИЙН ТИП
1	2	3	4	5	6
1	HOWO ZZ 1257 75-57 ДГО	Түлшний шүүр	ш	2	LZZ5BLMJ7MN9 43726
		Масло шүүр	ш	2	
		Чагтан гол	ш	2	
		Доторлогоо (кабин)	ш	1	
		Их гэрлийн ламп	ш	4	
		Подварын ламп	ш	4	
		Кабин халаагч	ш	1	
		Халуун тогоо	ш	1	
2	УАЗ 220695 33-56 ДГС	Свечи утас	ком	1	ХТТ220695К121 2716
		Перда диск	ш	1	
		Хаазны тросс	ш	1	
		Глушитель	ш	1	
		Сэнсний ремен	ш	2	
		Агаар шүүгч	ш	2	
		Денамны ремен	ш	2	
		Суудлын бүрээс	ш	11	
		Нормал баригч	ком	1	
		Катушка	ш	4	
		Наклад, (урд хойд)	ком	2	
		Гар карданы наклад	ш	2	
		Маслын шүүр	ш	2	
		3	HYUNDAI GOLD 14-61 ДГО	Өндөр даралтын шланк	
Төхөөрөмжийн кардан гол	ком			1	
Эргэх редүктерийн сальник	ш			1	SAC4340139
Богино кардан	ш			1	
Дунд гук	ш			1	
Масло шүүр	ш			2	
Түлшний шүүр	ш			2	
Их гэрлийн ламп	ш			2	
Подварын ламп	ш	4			
1	2	3	4	5	6
	HYUNDAI GOLD 14-61 ДГО	Дохионы ламп	ш	2	Soosan SAC-434
		Обуд	ш	1	
		Стартер	ш	1	
		Чагтан гол	ш	2	
		Гидрийн насос	ш	1	

		Өрмийн насос	ш	1	
		Туслах Карданы чагтан гол	ш	2	
		Агаар шүүгч	ш	2	
4	NISSAN NAVARA 34-00 ДГН	Түлшний шүүр	ш	2	MNTCCND23Z00 11916
		Агаар шүүгч	ш	2	
		Тосны шүүр	ш	2	
		Амортизатор	ш	4	
		Наклад (урд)	ш	2	
		Наклад (хойд)	ш	2	
		Босоо тэнцүүлэгч	ш	2	
				Тосны шүүр	
5	76-00 ДГН LANDCRUISER-200	Агаар шүүгч	ш	3	
		Амортизатор	ш	4	
		Ган диск	ш	1	
		Перда диск	ш	1	
		Муфьт шарик	ш	1	
		Наклад (урд)	ком	1	
		Наклад (хойд)	ком	1	
		Хойд барабан	ш	2	
		6	41-83 HINO	Тосны шүүр	ш
Түлшний шүүр	ш			2	
Агаар шүүгч	ш			2	
Амортизатор	ш			4	
Нум (урд)	ком			2	
Шил арчигч	ш			2	
Чагтан гол	ш			2	
Олгой хамер	ш			1	
Элгэвч	ш			1	
Арын гэрэл	хос			1	
Цахилгааны монтаж	ком			1	
Эх хавтан (гал хамгаалагч)	ком			1	
7	00-72 ДГА LAND-105			Тосны шүүр	ш
		Бензин шүүр	ш	2	
		Наклад (урд)	ш	1	
		Агаар шүүгч	ш	2	
		Пүрш	ш	4	
		Шарнер	ш	1	
		Үзүүрийн шарик	ш	1	
		Угийн шарик	ш	1	
		З	4	5	
		Цэцгэн түгжээ	ш	1	
		Ган шайв	ш	1	
		Наклад (хойд)	ком	1	
		Гар карданы наклад	ш	1	

## БАГЦ №2 БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

*[Захиалагч доорх хүснэгтийн 1-6 хүртэлх баганыг, тендерт оролцогч 7 дугаар баганыг бөглөнө ]*

№	Барааны нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	Өгөгдлийн хүснэгтэд заасан барааг хүргэх эцсийн цэг	Бараа нийлүүлэх хугацаа	
					Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа)	Нийлүүлэгчийн санал болгох хугацаа (Оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7
